

БАТЛАВ.
ТӨРИЙН НАРИЙН БИЙГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРДОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.БОЛОР-ЭРДЭНЭ

**“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД
НЭР ДЭВШИГЧИД ТАВИХ ШААРДЛАГА**

2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсэг, 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 85 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн “ИНҮТ” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг тодорхойлов.

Нэг. Хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд тавих ерөнхий шаардлага

1. Компанийн засаглалын сургалтад хамрагдсан байх;
2. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;
3. Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй байх;
4. Компанитай бизнесийн аливаа холбоогүй байх;
5. Компанитай хууль, шүүхийн маргаангүй, компанийн талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр үндэслэлгүй ташаа мэдээлэл тараагаагүй байх;
6. Эрүүгийн хуульд заасан эдийн засгийн, авлигын, өмчийн эсрэг гэмт хэрэгт шүүхийн шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдож байгаагүй байх;
7. Сүүлийн дөрвөн жил улс төрийн намын ажилтан, сонгуульт удирдах албан тушаал хашиж байгаагүй, эсхүл улс төрийн албан хаагчаар ажиллаж байгаагүй;
8. Эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээд нь дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь түүнээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон;
9. Тухайн компани, эсхүл түүний хараат болон охин компанитай нэгдмэл сонирхолтой болон компанийн үйл ажиллагаанд оролцогч талууд (зээлдүүлэгч, хувь нийлүүлэгч, хувьцааны багцыг эзэмшигч, хамтран ажиллагч г.м)-ын ашиг сонирхлыг төлөөлдөггүй байх;
10. Тодорхой албан тушаал эрхлэх буюу үйл ажиллагаа явуулах эрхийг нь шүүхийн шийдвэрээр хассан, Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэж шүүхээс ял шийтгүүлээгүй байх;
11. Тухайн салбарын төрийн өмчит, эсхүл хувийн өмчийн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаагүй байх.

Хоёр. Хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд тавих тусгай шаардлага

1. Иргэний нисэхийн чиглэлээр

- 1.1 Иргэний нисэхийн мэргэжлээр дээд боловсролтой байх /гадаад улсад магистрын зэрэг хамгаалсан бол давуу тал болно/;
- 1.2 Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- 1.3 Агаарын навигаци, аэродром, нисэх буудлын бодлого, төлөвлөлтийн чиглэлээр ажилласан туршлагатай байх;
- 1.4 Компанийн засаглал, менежментийн чиглэлээр ажилласан туршлагатай бол давуу тал болно.

2. Санхүү, эдийн засаг, аудитын чиглэлээр:

- 2.1 Санхүү, эдийн засаг, аудитын аль нэг мэргэжлээр дээд боловсролтой байх /гадаад улсад магистрын зэрэг хамгаалсан бол давуу тал болно/;
- 2.2 Хөрөнгө оруулалт, санхүүжилт хариуцсан удирдах албан тушаал эрхэлж байсан ажлын туршлагатай байх;
- 2.3 Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- 2.4 Иргэний нисэхийн салбарт ажилласан бол давуу тал болно;

Хууль эрх зүйн чиглэлээр:

- 3.1 Эрх зүйч мэргэжлээр дээд боловсролтой байх /гадаад улсад магистрын зэрэг хамгаалсан бол давуу тал болно/;
- 3.2 Хуульчийн мэргэшлийн шалгалт өгч, эрх авсан байх;
- 3.3 Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх, үүнээс 7-оос доошгүй жил хуульчаар ажилласан байх;
- 3.4 Компанийн засаглал, бизнесийн эрх зүйн чиглэлээр ажилласан туршлагатай бол давуу тал болно;
- 3.5 Иргэний нисэхийн салбарт ажилласан бол давуу тал болно.

Гурав. Сонгон шалгаруулалт оролцоход бүрдүүлэх материал

1. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт, өөрийн мэдлэг, ур чадвараа илэрхийлсэн өргөдөл (компанийн аль чиглэлийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй талаар тодорхой бичих);
2. Төрийн албан хаагчийн анкет, 4х6 хэмжээтэй цээж зураг;
3. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт /E-Mongolia лавлагаа байж болно/;
4. Боловсролын диплом, мэргэжлийн үнэмлэх, сургалт семинарт хамрагдсан гэрчилгээ, сертификатын хуулбар;
5. Иргэний үнэмлэхийн хуулбар /E-Mongolia лавлагаа байж болно/;
6. Банк, санхүүгийн байгууллагын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай лавлагаа;
7. Нэр дэвшигчид тавигдах нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан тухайгаа тодорхойлох лавлагаа болон бусад нэмэлт материалууд.